



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/82

Онги

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1дэх заалт, Малын, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, Мал эмнэлэгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/251 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулж, сумын хэмжээний бүх үхэр сүргийг бүрэн хамруулж, малчин мал бүхий иргэдэд тов мэдээг хүргэн бэлэн байдлыг хангуулан ажиллахыг Багийн Засаг дарга нар, Мал эмнэлэгийн тасагт үүрэг болгосугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг)

Гишүүд: Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Дэлгэрмаа)

“Онги Таван-Эрдэнэ” ХХК-ийн Малын эмч (Б.Цэнгэлмаа)

“Онги Таван-Эрдэнэ” ХХК-ийн малын эмч (Э.Энхсайхан)

“Онги” багийн Засаг дарга (Г.Пүрэв)

“Мааньт” багийн Засаг дарга (П.Энхсайхан)

“Найз” багийн Засаг дарга (Б.Ган-Оргил)

“Төгрөг” багийн Засаг дарга (Х.Энхтайван)

3. Дархлаажуулалтад шаардагдах зардлыг хууль журмын дагуу гарган зарцуулж, хяналт тавьж тайлан мэдээг үнэн зөв гаргаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал)-д үүрэг болгосугай.

4. Өөрийн аймгийн сум болон бусад аймаг сумын нутагт оторлож байгаа малчин өрхийн үхэр сүргийг тухайн орон нутагт дархлаажуулалтанд бүрэн хамруулах арга хэмжээг зохион байгуулах, дархлаажуулалтыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (Ц.Саранчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ц.АЛТАНГЭРЭЛ